## Гарчиг

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ ..... 2
1.1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ ..... 2
1.1.1. Төслийн нэр ..... 2
1.1.2. Төслийн зорилго ..... 2
1.1.3. Гүйцэтгэгч ..... 2
1.1.4. Гүйцэтгэгчийн хаяг, утас ..... 2
1.1.5. Төслийн талбайн байршил ..... 2
1.1.6. Төслийн товч танилцуулга, хүчин чадал ..... 4
1.1.7. Уурхайн ажиллах горим ..... 4
1.1.8. Уулын ажлын төлөвлөгөө ..... 4
2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..... 5
2.1. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ ..... 5
2.2. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ ..... 10
2.3. 2022 ОНЫ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ ..... 12
3. 2022 ОНЫ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ТАЙЛАН ..... 14
3.1. АГААРЫН БОХИРДОЛ ..... 14
3.2. ХӨРСНИЙ ХИМИ, ФИЗИК ШИНЖ ЧАНАР, ХҮНД МЕТАЛЛЫН ШИНЖИЛГЭЭ ..... 14
3.3. УСНЫ ХИМИЙН ШИНЖИЛГЭЭ ..... 15

## Зургийн жагсаалт

Зураг 1. Төслийн талбайн байршил ..... 2
Зураг 2. Төслийн талбай ..... 3
Зураг 3. Судалгааны талбайн харагдах байдал ..... 3
Зураг 4. Тээвэрлэлтийн үед хучлага хэрэглэж буй байдал ..... 6
Зураг 5. Хэрэглээний нүүрс хадгалах хэсэг ..... 6
Зураг 6. Ус ашигласны төлбөр төлсөн баримт ..... 7
Зураг 7. Шинээр хийсэн 00 ..... 7
Зураг 8. ШТС-ын хэсгийг хатуу хучилттай болгосон байдал ..... 8
Зураг 9. Нэмж байрлуулсан тэмдэг тэмдэглэгээ ..... 8
Зураг 10. Хог хаягдлын төлбөр төлсөн баримт ..... 9
Зураг 11. Тамхи татах цэгийн зураг ..... 9
Зураг 12. Ангилж хаях хогийн савыг шинээр байрлуулсан ..... 10
Зураг 13. Уурхайн талбайд шинээр суулгац суулгаж буй байдал ..... 10
Зураг 14. Талбайн нөхөн сэргээлт хийсэн байдал ..... 11
Зураг 15. Нөхөн сэргээлтийн зураг ..... 11
Зураг 16. Зүүн булагийн урсацыг сайжруулсан байдал / засаж цэвэрлэснээс 1 сарын дараа/ ..... 12

## Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Төслийн талбайн координат цэг ..... 2
Хүснэгт 2. Ил уурхайн ажлын горим ..... 4
Хүснэгт 3. Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө ..... 4
Хүснэгт 4. Агаар мандалд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ..... 5
Хүснэгт 5. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ... 6
Хүснэгт 6. Хөрсөн бүрхэвчид учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ..... 7
Хүснэгт 7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт ..... 8
Хүснэгт 8. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт ..... 10
Хүснэгт 9. Нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлууд ..... 10
Хүснэгт 10. Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд хийгдсэн ажлууд ..... 12
Хүснэгт 11. 2022 оны БОМТ-ний дагуу хийгдсэн ажлын биелэлтийн зардлын нэгдсэн тооцоо ..... 13
Хүснэгт 12. Агаарын чанарын хэмжилтийн дүн (9-р сар) ..... 14
Хүснэгт 13. Хөрсний химийн үндсэн шинж ..... 14
Хүснэгт 14. Хөрсний хүнд металлын сорьц ..... 14
Хүснэгт 15. Усны шинжилгээний дүн-1 ..... 15
Хүснэгт 16. Усны шинжилгээний дүн-2 ..... 15

# 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

## 1.1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

### *1.1.1. Төслийн нэр*

"Межик бридж" ХХК-ийн “Цогзол уулын хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах” төсөл

### *1.1.2. Төслийн зорилго*

Уул уурхайн үйлдвэрлэл хөгжүүлж жонш олборлох.

### *1.1.3. Гүйцэтгэгч*

Нэр: “Межик бридж” ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 9011112131

Регистрийн дугаар: 5175933

Тусгай зөвшөөрөл: MV-019018

### *1.1.4. Гүйцэтгэгчийн хаяг, утас*

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Гандирс цогцолбор, 504 тоот

Утас: 99103029, 98999999

### *1.1.5. Төслийн талбайн байршил*

Дундговь аймгийн Өлзийт сумын нутаг Өлзийт-1, Цогзол уул хэмээх газар. Улаанбаатар хотоос 310 км, Дундговь аймгийн төв Мандалговь хотоос зүүн урагш 80 км, Өлзийт сумаас баруун хойш 20км зайд тус тус оршино.

*Хүснэгт 1. Төслийн талбайн координат цэг*

| № | Уртраг | Өргөрөг |
|---|---|---|
| 1 | 106° 10' 1.34"E | 45° 07' 56.55"N |
| 2 | 106° 09' 1.34"E | 45° 07' 56.55'N |
| 3 | 106° 09' 1.34"E | 45° 10' 1.55"N |
| 4 | 107° 10' 1.34"E | 45° 10' 1.55"N |




*Зураг 1. Төслийн талбайн байршил*




*Зураг 2. Төслийн талбай*




*Зураг 3. Судалгааны талбайн харагдах байдал*

### *1.1.6. Төслийн товч танилцуулга, хүчин чадал*

Уурхайн хүчин чадлыг захиалагч байгууллагаас өгсөн төслийн даалгаварыг үндэслэн эхний жилд 30.0 мян.тн, 2,3,4-р жилд 90.0 мян.тн, 5-р жилд 75.3 мян.тн хүдэр олборлохоор ТЭЗҮ-д тусгасан байна. Ордын нийт үйлдвэрлэлийн нөөц нь 406.4 мян.тн байна. Уурхайн нийт ажиллах хугацааг 5 жил байхаар тооцсон. Уурхайн нь жилд 6 сар буюу 160 хоног, хоногт 10 цагаар 2 ээлжээр ажиллах бөгөөд ажиллах хүчин 25 хүн байна.

### *1.1.7. Уурхайн ажиллах горим*

Уулын ажил нь жилд 6 сар явагдана. Үйлдвэрлэлийн үндсэн процессууд нь тасралтгүй 7 хоног, өдөрт 2 ээлжээр 10 цагаар явагдана.

Үйлдвэрлэлийн бусад ажил болох цахилгаан хангамж, усан хангамж, гэрэлтүүлэг зэрэг үйлдвэрлэлийн дотоод ажлын зохион байгуулалтаар хийнэ. Уурхайн ажиллах горимыг захиалагч байгууллагын техникийн даалгавар, уурхайн жилийн хүчин чадалтай нь уялдуулан дараах байдлаар сонгов.

*Хүснэгт 2. Ил уурхайн ажлын горим*

| Үзүүлэлт | Х.нэгж | Хоног |
|---|---|---|
| Календарь хоног | хоног | 180 |
| Жилд ажиллах сар | сар | 6 |
| Ээлжийн үргэлжлэх хугацаа | цаг | 10 |
| Ээлжийн тоо | ээлж | 2 |
| Баяр ёслолын хоног | хоног | 10 |
| Цаг агаарын саатал | хоног | 8 |
| Бэлтгэл ажлын хоног | хоног | 2 |
| **Жилд ажиллах хугацаа** | **хоног** | **160** |

### *1.1.8. Уулын ажлын төлөвлөгөө*

Өлзийт-1 хүдрийн биетэд 573.2 мян.м3 хөрс хуулж, 164.5 мян.тн хүдэр, Цогзол-Уулын хүдрийн биетэд 856.5 мян.м3 хөрс хуулж, 215.5 мян.тн хүдэр олборлохоор байна.

*Хүснэгт 3. Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө*

| **Ашиглалтын жилүүд** | **Хүдрийн нөөц** | | **Дундаж агуулга** | **Металлын нөөц** | **Хөрс хуулалтын хэмжээ** | **Хөрс хуулалтын коэффициент** |
|---|---|---|---|---|---|---|
| | **$м^3$** | **тн** | **%** | **тн** | **$м^3$** | **$м^3$/тн** |
| 2022 он | 11,538 | 30,000.0 | 39.2 | 11,760.0 | 138,675.0 | 4.6 |

# 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Межик бридж” ХХК-ийн “Цогзол уулын хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах” төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль болон бусад холбогдох хууль, журам, стандартыг баримтлан, “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын дагуу боловсруулсны үндсэн дээр биелэлтийн тайланг хийж гүйцэтгэсэн болно.

## 2.1.БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

*Хүснэгт 4. Агаар мандалд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт*

| № | Болзошгүй сөрөг нөлөөлөл | Гүйцэтгэсэн ажил | Зардал мян.төг |
|---|---|---|---|
| 1 | Уурхайн олборлолт болон тээврийн хэрэгслүүдийн үйл ажиллагааны улмаас гарч болох тоосжилтын эх үүсвэрүүд: | Уурхайлалтын үйл ажиллагааны үед хуурайшилттай байх тохиолдолд усалгааг тогтмол хийж байсан. | Хүснэгт 5-д орсон. |
| | | Тоос шороо их босгодог ажилд байгалийн болон зориудаар хийсэн салхины чиглэл өөрчлөх, хурд сааруулах байгууламж, хаалтуудыг 2023 оны ажилд төлөвлөн барина. | - |
| | | Овоолгыг салхи ихтэй үед услах арга хэмжээ тогтмол хийсэн бөгөөд усалгааны зардалд орно. Мөн шимт хөрсний ургамал ургах нөхцлийг бүрдүүлж байгалийн аясаар ургамалжих боломжийг хангасан. | Хүснэгт 5-д орсон. |
| | | Хүдэр тээвэрлэх машинуудыг тэвшний бүтээлгээр хангаж, ашиглалтанд нь хяналт тавих, хурдыг хязгаарлаж 30 км/ цагаар хязгаарлалт тогтоосон. | 350.0 |
| | | Ажлын байрны температур, чийглэг, гэрэлтүүлэг, шуугиан, агаарын чанар найрлага, цацрагийн хэмжээ зэргийг тодорхойлуулах ажлыг 2023 онд гүйцэтгэх ажилд тусгасан болно. | - |
| | | Хүчтэй салхи, шуургатай үед олборлолтын үйл ажиллагааг түр зогсоосон. | - |
| 2 | Хүдэр тээвэрлэх үед хүнд даацын машин механизмын хөдөлгөөнөөр сул шороо үүсч, тоосжилт ихсэж агаарын чанарт нөлөөлөх<br>Машин техник, тоног төхөөрөмжийн хөдөлгүүрийн яндангаас гарах утаа, тортог бусад элемент зэрэг нь агаарын чанарт нөлөөлөх | Хүдэр ялгах, бутлах, шигших, ачих шугамын тоосжилтыг хянаж, тоос бууруулах ажил болох БОННҮ-д тусгасан зөвлөмж болох манажуулах суурин төхөөрөмжийг 2023-2024 онд гүйцэтгэнэ. | - |
| | | Жонш бутлах цех рүү буулгахдаа автомашины хурдыг тохируулах аль болох бага байлгах арга хэмжээг авч ажиллаж байна. | - |
| | | Уурхайн кепт ашиглагдах нүүрсийг шаталт өндөр, цацраг идэвхит хоруу чанар багатай сайн чанарын нүүрсийг сонгож хэрэглэж байна. | ҮА зардал |
| | | Нүүрсний ил агуулахыг эмх замбараатай болгосон бөгөөд дараа жилийн | 200.0 |

| | | | |
|---|---|---|---|
| | | төлөвлөгөөнд түр хадгалах газрыг битүү болгохоор төлөвлөж байна. | |
| | | Уурхайн экскаватор, автосамосвалуудын шатахуун зарцуулалтыг өдөр бүр хянаж, доголдолтой их түлш зарцуулж буй техникийг ажилд гаргахгүй байх, засвар үйлчилгээнд оруулахыг шаардах | ҮА зардал |
| | | Гоожсон тос масло, түлшийг цэвэрлэх материалын нөөцийг бий болгосон. | ҮА зардал |
| | | Тоосжилтыг дарах үүднээс мананжуулах төхөөрөмжийг 2023-2024 онд багтаан ашиглаж эхлэхээр төлөвлөсөн. | - |
| | **Дүн** | | **550.0** |



*Зураг 4. Тээвэрлэлтийн үед хучлага хэрэглэж буй байдал*



*Зураг 5. Хэрэглээний нүүрс хадгалах хэсэг*

*Хүснэгт 5. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт*

| № | Болзошгүй сөрөг нөлөөлөл | Гүйцэтгэсэн ажил | Зардал мян.төг |
|---|---|---|---|
| 1 | Төслийн үйл ажиллагааны улмаас гүний усанд бохирдол үүсэх, гүний усны нөөцөд сөрөг нөлөөлөл үзүүлэх | Ахуйн бохир ус зайлуулах цооногийг 2023 оны 2-р улиралд багтаан дуусгана. | - |
| | | Усалгааны усны хэрэглээг хэмнэлттэй зарцуулах үүднээс 2023 оноос зохиомол манажуулах төхөөрөмжийг ашиглаж эхлэхээр төлөвлөсөн. | - |
| | | Ус ашиглалтын төлбөрийг төлсөн. | 1 056.6 |
| | | Бохир ус болон үерийн ус зайлуулах суваг хоолойн оруулга, гаргалгыг сайн чанарын хоолойг сонгохоор судалгаа хийж байна. | - |
| | | Унд-ахуйн хэрэглээнд ашиглагдаж буй гүний худгийн усыг ОХШХ-ийн дагуу шинжилгээг хийлгэж байгаа. | ОХШХ-ийн зардалд орсон |

| | | | |
|---|---|---|---|
| | | Худгийн насос болон ус дамжуулах хоолойн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд засвар үйлчилгээг гүйцэтгэсэн. | 150.0 |
| | | 00-ыг шинээр барин доторлогоо хийсэн. | 2 296.0 |
| | | 2022 онд уурхайн шүүрлийн уснаас дээж авч лабораторид шинжлүүлсэн. (шинжилгээний хариуг хавсаргав) | 60.0 |
| | **Дүн** | | **3 562.6** |


ТӨРИЙН БАНК
МӨНГӨН ШИЛЖҮҮЛЭГ / MONEY TRANSFER

*Зураг 6. Ус ашигласны төлбөр төлсөн баримт*



*Зураг 7. Шинээр хийсэн 00*

*Хүснэгт 6. Хөрсөн бүрхэвчид учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт*

| № | Болзошгүй сөрөг нөлөөлөл | Гүйцэтгэсэн ажил | Зардал мян.төг |
|---|---|---|---|
| 1 | Уурхайн олборлолтын улмаас хөрсөн бүрхэвч нөлөөлөлд өртөх Тэмдэг тэмдэглэгээ хангалттай байрлуулаагүйгээс төлөвлөлтөөс гадуур олон салаа зам үүсэх | Үржил шимт хөрсийг нимгэн зузаанаас хамааруулан 15-20 см-ийн зузаантай хуулж, нөхөн сэргээлтэнд буцаан ашиглах зориулалтаар шимт хөрсний овоолго үүсгэн ажиллаж байна. | ҮА-ны зардалд орсон |
| | | Уурхайн зам болон олборлолтын хэсгийн тэмдэг тэмдэглэгээг нэмсэн. (16 ширхэг) | 7 712.0 |
| | | ШТМ-ын хадгалах хэсэг болон автомашины засварын хэсгийг 2023 оны 1-р улиралд тусгайлан засч тохижуулна. | - |
| | | Хөрсний бохирдол үүсэхээс сэргийлэх болон олон салаа зам гаргахгүй байх талаар жолооч операторуудад сануулж төлөвлөгөөний дагуу замыг гаргаж ажиллаж байна. | - |

| | | | |
|---|---|---|---|
| | | Ажлын талбай ба туслах зам дагуу үүссэн хотос хонхор зэрэг хөрсний элэгдэл, эвдрэлийг их бага гэхгүйгээр тухай бүр нь дүүргэх, тэгшлэх, талбайн эмх цэгцтэй байдлыг хангаж ажиллаж байна. | ҮА-ны зардалд орсон |
| 2 | Машин техникийн тос тосолгооны материал, шатах тослох материал болон нефтийн бүтээгдэхүүн асгаралтаас хөрс бохирдох | Автомашины тос тосолгоонд ашиглаж байсан тос маслын хаягдлыг зориулалтыг газарт хадгалаж байгаа. | - |
| | | ШТС-ын хэсгийг хатуу хучилттай болгож тохижуулсан | 4 125.0 |
| 3 | Уурхайн гал тогоо, угаалга цэвэрлэгээнээс гарах бохир ус нь хөрсний бохирдол үүсгэх | Бохирын цооногийн жил бүрийн засвар үйлчилгээг гүйцэтгэсэн. | - |
| | **Дүн** | | **11 837.0** |



*Зураг 8. ШТС-ын хэсгийг хатуу хучилттай болгосон байдал*



*Зураг 9. Нэмж байрлуулсан тэмдэг тэмдэглэгээ*

*Хүснэгт 7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт*

| № | Болзошгүй сөрөг нөлөөлөл | Гүйцэтгэсэн ажил | Зардал мян.төг |
|---|---|---|---|
| 1 | Аюултай хог хаягдлын бүртгэлийг бий болгох | Хатуу хог хаягдлыг ангилан ялгаж, зайлуулах, дахин ашиглах тогтолцоог нэвтрүүлэх үүднээс хогийг ялган ангилаж хаях хогийн савыг ашиглаж байна. | 350.0 |
| | | Хатуу хог хаягдлыг цуглуулж нэгдсэн цэгт хүргэж устгах ажлыг тогтмол хийж байна. | - |
| | | Хог хаягдлыг цуглуулах савыг битүүмжтэй болон салхи орж байх савыг сонгон авсан. | Хүснэгт 7-ын 1-р мөрөнд |
| | | Аюултай хог хаягдал болох ажилласан тос масло түр хадгалах сав болон аккумляторыг | - |

| | | | |
|---|---|---|---|
| | | тусгайлсан хэсэгт хадгалж гэрээний дагуу зайлуулах, бүртгэлжүүлэх ажлыг 2023 оны үйл ажиллагаа эхлэхэд бүрэн хэрэгжүүлнэ. | |
| | | Хаягдал дугуй болон төмрийн хаягдлыг ангилан цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх ажлыг жил бүр хийж байгаа. | - |
| 2 | Уурхайн ажилчдын ахуйн болон автомашины гаралтай хог хаягдлыг ангилан ялгаж зориулалтын цэг дээр хадгалаагүйн улмаас хөрс, гүний ус, агаар, ургамал, амьтан, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх | Уурхайд үүссэн хог хаягдлыг өөрийн техникээр 2 догч түүхий эд болох шил, лааз, хуванцар савыг түүхий эдийн төвд хүргэж байна. | - |
| | | Ажилчдын тамхи татах цэгийг шинээр байрлуулсан. | 50.0 |
| | | Хог хаягдлын гэрээний дагуу хог хаягдал зайлуулах төлбөрийг төлсөн. | 1 184.0 |
| | | Шингэн хаягдлыг бодис ашиглан задлахыг 2023 оноос туршиж үзнэ. | - |
| | **Дүн** | | **1584.0** |


ТӨРИЙН БАНК
МӨНГӨН ШИЛЖҮҮЛЭГ / MONEY TRANSFER
Хүлээн авагчийн / Beneficiary's
1,184,000.00
MNT
Илгээгчийн / Sender's
1,184,000.00
MNT

Зураг 10. Хог хаягдлын төлбөр төлсөн баримт






Зураг 11. Тамхи татах цэгийн зураг




*Зураг 12. Ангилж хаях хогийн савыг шинээр байрлуулсан*

*Хүснэгт 8. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт*

| № | | Гүйцэтгэсэн ажил | Зардал мян.төг |
|---|---|---|---|
| 1 | Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн ажлууд | Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан. | 1 200.0 |
| | | Байгаль орчны мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө авсан. | 1500.0 |
| | | Нутгийн овооны тахилгад хандив өгсөн. | 2 000.0 |
| | | Өлзийт суманд 2000 боодол өвс өгсөн. | 40 000.0 |
| | | Нөлөөллийн бүсийн айлуудад 3200 боодод өвс тараасан. | |
| | | Нутгийн иргэдэд судар хэвлүүлж тараах ажилд хандив туслалцаа үзүүлсэн. | 1 260.0 |
| | | Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг шинэчилэн хийлгэсэн. | 4 400.0 |
| | **Дүн** | | **50 360.0** |

## 2.2.НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Уурхай нь 2022 онд биологийн нөхөн сэргээлт хийгдээгүй бөгөөд хотхоны тохижилт, ногоон байгууламж үүсгэх, арчилгаа тордлогоог хийж гүйцэтгэсэн болно. Техникийн нөхөн сэргээлтийг лицензийн талбайд байрлах хууль бусаар жонш олборлогчдын ухаж орхисон 1 га талбайд гүйцэтгэсэн. Уг техникийн нөхөн сэргээлтийн зардал нь үйл ажиллагааны зардалд хамаарч байна.

*Хүснэгт 9. Нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлууд*

| № | Хийж гүйцэтгэсэн ажлууд | Зардал мян.төг |
|---|---|---|
| 1 | Төслийн талбайд 150 ширхэг суулгац нэмж суулган арчилгааг тордлогоог гүйцэтгэж байна. | 5 750.0 |
| 2 | Техникийн нөхөн сэргээлт 1 га (хуучин ухагдсан байсан талбай) | 370 500.0<br>/ҮА-ны зардал/ |
| | **Дүн** | **5 750.0** |



*Зураг 13. Уурхайн талбайд шинээр суулгац суулгаж буй байдал*



*Зураг 14. Талбайн нөхөн сэргээлт хийсэн байдал*



*Зураг 15. Нөхөн сэргээлтийн зураг*

## 2.3. 2022 ОНЫ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Дүйцүүлэн хамгаалах ажлыг орон нутгаас өгсөн заавар зөвлөмжийн дагуу Өлзийт сумын нутаг, төслийн талбайгаас зүүн хойд зүгт байрлах Зүүн булаг хэмээх булгийн эхийн урсацыг сайжруулах, элсэнд дарагдаж урсахаа больсон байсныг засаж цэвэрлэх ажлыг нутгийн иргэдийн оролцоотой хийж гүйцэтгэсэн. Мөн талбайгаас урагш орших Гурван ухаа шахааны аманд байрлах 5 га эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн ажлыг 2023 оноос эхлэн гүйцэтгэж эхлэх байсан боловч 2022 оны 3-р улиралд багахан хэмжээний техникийн нөхөн сэргээлт хийж зарим газрыг тэгшилж янзлаад үлдээсэн болно. Тус нөхөн сэргээлт хийх эвдэрсэн газар нь төслийн талбайгаас 100 орчим км-ийн зайд машин техник хүрэхэд хүндрэлтэй бартаа ихтэй газарт байрлаж байна.

*Хүснэгт 10. Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд хийгдсэн ажлууд*

| № | Хийж гүйцэтгэсэн ажлууд | Зардал мян.төг |
|---|---|---|
| 1 | Зүүн булагийн эхийг засаж цэвэрлэх ажил | 2 500.0 |
| 2 | Гурван ухаа шахааны ам | 3 000.0 |
| | **Дүн** | **5 500.0** |





*Зураг 16. Зүүн булагийн урсацыг сайжруулсан байдал / засаж цэвэрлэснээс 1 сарын дараа/*

*Хүснэгт 11. 2022 оны БОМТ-ний дагуу хийгдсэн ажлын биелэлтийн зардлын нэгдсэн тооцоо*

| № | Бүрэлдэхүүн хэсгүүд | Зардал мян.төг |
|---|---|---|
| 1 | Агаар мандалд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн зардал | 200.0 |
| 2 | Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн зардал | 3 562.6 |
| 3 | Хөрсөн бүрхэвчид учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн зардал | 11 837.0 |
| 4 | Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлтийн зардал | 1 580.0 |
| 5 | Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийн зардал | 50 360.0 |
| 6 | Нөхөн сэргээлтийн арга хэмжээний биелэлтийн зардал | 5 750.0 |
| 7 | 2022 оны дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний биелэлтийн зардал | 5 500.0 |
| 8 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт, үр дүнгийн хэлэлцүүлгийн тэмдэглэл | 230.0 |
| | **Нийт дүн** | **79 019.6** |

# 3. 2022 ОНЫ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ТАЙЛАН

## 3.1. Агаарын бохирдол

*Хүснэгт 12. Агаарын чанарын хэмжилтийн дүн (9-р сар)*

| № | Сорьц авсан цэг | Сорьц авсан өдөр | Сорьц авсан цаг | Хүхэрлэг хий мг/м$^3$ | Азотын давхар исэл мг/м$^3$ | Нийт тоом /TSP/мг/м$^3$ | Дуу чимээ /ДБА/ |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Ажилчдын кемп | X/23 | 10:15 | 0.018 | 0.024 | 0.077 | 45 |
| 2 | Олборлолтын талбайн хойд хэсэг | X/23 | 12:15 | 0.017 | 0.022 | 0.088 | 60 |
| 3 | Олборлолтын талбайн урд хэсэг | X/23 | 10:15 | 0.020 | 0.025 | 0.090 | 50 |
| **Агаарын чанарын стандарт MNS 4585:2016** | | | | **0.450** | **0.200** | **0.500** | **60** |

Тайлбар:

Хүхэрлэг хийн ($SO_2$) агууламж зөвшөөрөгдөх хэмжээнээс даваагүй, азотын давхар ислийн ($NO_2$) агууламж агаарын чанарт сөрөг нөлөөлөл үзүүлэх хэмжээний байхгүй ба тоосонцрын хэмжээ зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс даваагүй ч нүүрс ачих, бутлах хэсэгт их, дуу чимээний хэмжээ ЗДХ-ээс даваагүй байна.

## 3.2. Хөрсний хими, физик шинж чанар, хүнд металлын шинжилгээ

Хөрсний морфологи тогтоцын хувьд хүрэн өнгөтэй, нягт, жижиг чулуутай, ургамлын үндэстэй, ургаман бүрхэвч 70%, хуурай, бүтэц алдагдсан, үе давхарга хоорондын шилжилт тод байна.

Хөрс нь сул хүчиллэгээс сул шүлтлэг урвалын орчинтой, карбонатгүй, ялзмагийн агууламж бага зэрэг, цахилгаан дамжуулах чанар бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнт фосфорынн хангамж бага зэрэг, хөдөлгөөнт калийн хангамжаар бага, механик бүрэлдэхүүн элсэнцэр. Хөрсний үржил шимийн ерөнхий түвшин бага байна.

Хөрсний лабораторийн задлан шинжилгээний дүнгээс үзэхэд ялзмагийн хэмжээ 0.24%, хөрсний pH 10.14, хөдөлгөөнт фосфор 1.9мг байгаа зэрэг нь хөрсний хими шинж чанарын түвшин болон ургамал ургах орчин хангалттай сайн байна.

*Хүснэгт 13. Хөрсний химийн үндсэн шинж*

| Дээж | Гүн, см | pH | Давс, % | ЦДЧ, dsm | Ялзмаг,% | $CaCO_2$,% | Шингээгдсэн сууриуд мг-экв/100гр | | Шим тэжээлийн элементүүд мг/100гр | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Ca | Mg | $P_2O_5$ | $K_2O$ |
| Зүсэлт-1 | 0 | 10.14 | 0.02 | 0.042 | 0.24 | 0.00 | 9.0 | 4.6 | 1.7 | 27 |
| Зүсэлт-2 | 0 | 10.64 | 0.07 | 0.142 | 0.22 | 0.00 | 8.8 | 3.3 | 1.8 | 25 |
| Зүсэлт-3 | 0 | 10.85 | 0.12 | 0.276 | 0.17 | 0.64 | 3.9 | 2.7 | 0.5 | 10 |
| Зүсэлт-4 | 0 | 10.85 | 0.33 | 0.663 | 0.05 | 0.64 | 5.2 | 2.8 | 1.1 | 17 |

Хөрсний механик бохирдол буюу хүнд металлын агууламжийг төслийн талбайд 2 цэг сонгон авч шинжлүүлэхэд ЗДХ-ээс хэтэрсэн буюу бохирдолтой хөрс илрээгүй байна.

*Хүснэгт 14. Хөрсний хүнд металлын сорьц*

| № | Сорьц авсан цэгийн нэр | Хүнд металл мг/кг | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Cd /кадми/ | Pd /хар тугалга/ | Hg /мөнгөн ус/ | Cr /хром/ | Zn /цайр/ | Cu /зэс/ | Co /кобальт/ | Sr /стронци/ |
| | | мг/кг | | | | | | | |
| 1 | Ажилчдын кемп | 0.1 | 8.0 | <0.005 | <0.005 | 33.8 | 29.3 | 10.6 | 588.0 |
| 2 | Уурхайн салхины доод орчмоос | <0.005 | 11.0 | <0.005 | <0.005 | 66.5 | 28.9 | 20.7 | 516.6 |
| **MNS 5850:2019 /ЗХД/** | | **3** | **100** | **2** | **150** | **300** | **100** | **50** | **800** |

## 3.3. Усны химийн шинжилгээ

Төслийн ахуйн хэрэглээний усыг өөрийн талбайд гаргасан гүний худгаас ашигладаг бөгөөд уг худгаас дээжлэлт хийсэн усны химийн задлан шинжилгээний дүнг дараах хүснэгтэд харуууллаа. Шинжилгээний дүнд худгийн ус нь химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, магнийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэг буюу дунд зэргийн эрдэсжилттэй, хатуу ус байна гэж гарчээ.

*Хүснэгт 15. Усны шинжилгээний дүн-1*

| Сорьцын нэр | pH | EC µS/см | $SO_4$ мг/л | CI мг/л | Ca мг/л | Mg мг/л | Na+K мг/л | $HCO_3$ мг/л | Эрд мг/л | Хат мг-экв/л |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Дундговь аймаг Өлзийт сум 4-р баг Хайлуур жоншны орд, гүний худаг | 7.61 | 492 | 29.7 | 29.4 | 80.9 | 5.9 | 0.5 | 189 | 335 | 4.53 |
| **MNS 0900:2018** | **6.5-8.5** | **1000** | **500** | **350** | **100** | **30** | **-** | **-** | **-** | **7.0** |

*Хүснэгт 16. Усны шинжилгээний дүн-2*

| Сорьцын нэр | Ж/б мг/л | ПИЧ мг/л | $NH_4$-N мг N/л | $NO_2$-N мг N/л | $NO_3$-N мг N/л | $PO_4$ мгP/л | Fe мг/л | F мг/л |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Дундговь аймаг Өлзийт сум 4-р баг Хайлуур жоншны орд, гүний худаг | 5.6 | 0.5 | 0.01 | 0.009 | 69.1 | 0.004 | 0.02 | 0652 |
| **MNS 0900:2018** | **-** | **-** | **1.5** | **1.0** | **50** | **3.5** | **0.3** | **0.7-1.5** |

"МЭЖИК БРИДЖ" ХХК-ний "ӨЛЗИЙТ 1" ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДАГУУ 3-Р БАГИЙН НУТАГТ "ГУРВАН УХАА ШАХААНЫ АМ" НЭРТЭЙ ТАЛБАЙД НӨХӨН СЭРГЭЭЛТ ХИЙСЭН АЖЛЫГ ХҮЛЭЭН АВСАН ТУХАЙ АКТ

2023 оны 02 дугаар сарын 02-ний өдөр

| № | Мэдээлэл, асуулт |
|---|---|
| 1 | Байршил<br>Аймаг, сум, газрын нэр: Дундговь аймаг, Өлзийт сум, 3-р баг |
| 2 | Аж ахуй нэгжийн нэр: "Мэжик Бридж" ХХК<br>Хаяг: УБ хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, 26-504 тоот<br>Холбоо барих утас: 98999999, 93003636<br>И-Майл хаяг: magicbridgebe@gmail.com<br>Гэрчилгээний дугаар: 9011113121<br>Регистрийн дугаар: 5175933 |
| 3 | Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-019018<br>Ордын нэр: "Өлзийт 1"<br>Талбайн хэмжээ /га/: 505.45 |
| 4 | Нөхөн сэргээлт хүлээлгэн өгсөн: "Мэжик Бридж" ХХК<br>Албан тушаалын нэр: Уурхайн дарга<br>Овог, нэр: В.Лувсандамдин<br>Холбоо барих утас: 96664320 |
| 5 | Нөхөн сэргээлтийн ажлыг газар дээр нь хэмжиж зураглал үйлдсэн мэргэжлийн байгууллагын нэр: Байхгүй<br>Хаяг: Өлзийт сумын 3-р баг "Гурван ухаа шахааны ам" |
| 6 | Нөхөн сэргээлтийн ажлын хэмжээ, чанар үр дүн |
| 7 | Нөхөн сэргээлтийн хэмжээ:<br>1. Техникийн нөхөн сэргээлт<br>Талбайн хэмжээ /м²/- 9000<br>Зардал /төгрөг/-3.000.000 |

| | |
|---|---|
| | 2. Биологийн нөхөн сэргээлт хэмжээ: Биологийн нөхөн сэргээлт хийгдээгүй. |
| 8 | Нэмэлт мэдээлэл: Өлзийт сумын 3 дугаар багийн нутагт орших "Гурван ухаа шахааны ам" нэртэй газарт ашигт малтмал олборлолтын улмаас эвдрэлд өртсөн талбайд нөхөн сэргээлт хийсэн |

**Нөхөн сэргээлтийн ажлын дүгнэлт:**

"Мэжик Бридж" ХХК нь ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий "Өлзийт 1" хайлуур жоншны ордын 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу 3-р багийн нутагт "Гурван ухаа шахааны ам" нэртэй 0.9 га талбайд 2023.01.01-н өдөр техникийн нөхөн сэргээлтийг чанартай хийж гүйцэтгэсэн тул талбайд сумын Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг ажиллаж нөхөн сэргээлтийн акт үйлдэн хүлээн авав.

**АКТ ГАРГАСАН:**

**Комиссын дарга:**

Дундговь аймгийн Өлзийт сумын

Засаг даргын орлогч ........................ / Х.Шинэбаатар /

**Гишүүд:**

Байгаль Орчны Хяналтын Улсын байцаагч ........................ / Г.Жадамба /

Багийн засаг дарга ........................ / М.Айлтгүй /

**ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН:**

"Мэжик Бридж" ХХК-ийн ЗАХИРАЛ ........................ /О.Эгшиглэн/

/ 2023 оны 02 сарын 02 өдөр /

"МЭЖИК БРИДЖ" ХХК-ний "ӨЛЗИЙТ 1" ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДАГУУ 4-Р БАГИЙН НУТАГТ "ӨЛЗИЙТ 1" НЭРТЭЙ ТАЛБАЙД НӨХӨН СЭРГЭЭЛТ ХИЙСЭН АЖЛЫГ ХҮЛЭЭН АВСАН ТУХАЙ АКТ

2023 оны 02 дугаар сарын 02-ний өдөр

| № | Мэдээлэл, асуулт |
|---|---|
| 1 | Байршил<br>Аймаг, сум, газрын нэр: Дундговь аймаг, Өлзийт сум, 4-р баг |
| 2 | Аж ахуй нэгжийн нэр: "Мэжик Бридж" ХХК<br>Хаяг: УБ хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, 26-504 тоот<br>Холбоо барих утас: 98999999, 93003636<br>И-Майл хаяг: magicbridgebe@gmail.com<br>Гэрчилгээний дугаар: 9011113121<br>Регистрийн дугаар: 5175933 |
| 3 | Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-019018<br>Ордын нэр: "Өлзийт 1"<br>Талбайн хэмжээ /га/: 505.45 |
| 4 | Нөхөн сэргээлт хүлээлгэн өгсөн: "Мэжик Бридж" ХХК<br>Албан тушаалын нэр: Уурхайн дарга<br>Овог, нэр: В.Лувсандамдин<br>Холбоо барих утас: 96664320 |
| 5 | Нөхөн сэргээлтийн ажлыг газар дээр нь хэмжиж зураглал үйлдсэн мэргэжлийн байгууллагын нэр: Байхгүй<br>Хаяг: Өлзийт сумын 4-р баг Өлзийт 1 |
| 6 | Нөхөн сэргээлтийн ажлын хэмжээ, чанар үр дүн |
| 7 | Нөхөн сэргээлтийн хэмжээ:<br>1. Техникийн нөхөн сэргээлт<br>Талбайн хэмжээ /м²/- 10.000<br>65.000 м³ |

| | |
|---|---|
| | Зардал /төгрөг/-<br>2. Биологийн нөхөн сэргээлт хэмжээ: Биологийн нөхөн сэргээлт хийгдээгүй. |
| 8 | Нэмэлт мэдээлэл: Өлзийт сумын 4 дугаар багийн нутагт орших "Өлзийт-1" нэртэй газарт Өөрийн ашигт малтмал олборлолт явуулсан талбайн нөхөн сэргээлт |

**Нөхөн сэргээлтийн ажлын дүгнэлт:**

"Мэжик Бридж" ХХК нь ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий "Өлзийт 1" хайлуур жоншны ордын 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу 4-р багийн нутагт "Өлзийт1" нэртэй 1 га талбайд 2022.10.24-н өдөр техникийн нөхөн сэргээлтийг чанартай хийж гүйцэтгэсэн тул талбайд сумын Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг ажиллаж нөхөн сэргээлтийн акт үйлдэн хүлээн авав.

**АКТ ГАРГАСАН:**

**Комиссын дарга:**

Дундговь аймгийн Өлзийт сумын

Засаг даргын орлогч ............................ / Х.Шинэбаатар /

**Гишүүд:**

Байгаль Орчны Хяналтын Улсын байцаагч ............................ / Г.Жадамба /

Багийн засаг дарга ............................ / У.Гантогтох /

**ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН:**

"Мэжик Бридж" ХХК-ийн ЗАХИРАЛ ............................ /О.Эгшиглэн/

/ 2023 оны 02 сарын 02 өдөр /

**ХОГ ХАЯГДЛЫН ГЭРЭЭ**

2022 он 07 сарын 01 өдөр №МВ2207/02 Рашаант

**Нэг . Нийтлэг үндэслэл**

Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17-р зүйлийн 2,6 дахь заалт , Хог хаягдлын тухай хуулийн 8.4, 9.2, 20.1, 20.2 дугаар зүйл, Сумын ИТХ-ийн 2019 оны 04 дүгээр сарын 18-ны 40 тоот тогтоолыг үндэслэв.

Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах түүнээс урьдчилан сэргийлэх ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, дахин боловсруулж эргүүлэн ашиглах, тээвэрлэх булах болон орчны ариун цэврийг тогтмол цэвэр байлгах, цэвэр эрүүл орчинд ажиллаж амьдрах орчныг бий болгоход оршино.

**Хоёр. Гэрээ байгуулагч талууд**

Нэг талаас **Дундговь аймгийн Өлзийт сумын ЗДТГ-ыг** төлөөлж Засаг дарга **Б.Гасрандорж** нөгөө талаас УБ хот, Баянгол дүүрэг, 1-р хороо, 2-р хороолол, 64-40 тоот, хаягтай **9011113121** тоот улсын бүртгэлийн гэрчилгээ, **5175933** тоот регистрийн дугаартай Дундговь аймгийн Өлзийт суман дахь "Өлзийт-1" нэртэй газарт ашиглалтын **MV-019018** тусгай зөвшөөрөл эзэмшигч "**Мэжик Бридж**" ХХК-ны гүйцэтгэх захирал **Оюун-Од** овогтой **Эгшиглэн** нар харилцан тохиролцож 1 жилийн хугацаатай энэхүү гэрээг байгуулав.

**Гурав. Төлбөр тооцсон байдал**

Өлзийт сумын ИТХ-ын 2019 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 40 дүгээр тоот тогтоолын 25-д заасны дагуу уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгжид хог хаягдал гаргасны 2022 оны төлбөр болох 1,184,000 төгрөгийг 100080800947 хог хаягдлын хураамжийн дансанд төвлөрүүлэх.

**Дөрөв. Сумын ЗДТГ эрх, үүрэг**

1 . Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Хог хаягдлын хууль, Ариун цэврийн тухай хуулийн дагуу хяналт тавьж ажиллах

2 . Иргэд аж ахуйн нэгж , байгууллагын хог хаягдал гаргасны төлбөрийг төвлөрүүлэх

3 . Иргэд аж ахуйн нэгж , байгууллагын хог хаягдлаа зориулалтын цэгт хаяж байгаа эсэхэд хяналт тавих

4. Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх хуваарийг тээвэрлэгчтэй гэрээ байгуулж хэрэгжилтэнд хяналт тавих

**Тав. Иргэн ААН байгууллагын эрх үүрэг**

1. Өөрийн байгууллагын үйл ажиллагаанаас гарсан ахуйн хуурай хог хаягдлыг стандартын шаардлага хангасан зориулалтын саванд хадгалж байх.

2. ААН байгууллага нь хог хаягдал гарсан төлбөрөө 4 дүгээр улиралд багтаан **100080800947** тоот дансанд шилжүүлж байна. /төрийн сан банк/

3. Хог хаягдлыг ангилан ялгаж байх

4. Ахуйн болон үйлдвэрлэлийн хогийг тогтсон хугацаанд цэвэрлэж тээвэрлэх, хог хаягдлын талаархи дүрэм журам, стандартын шаардлагыг хангаж зориулалтын цэгт хаяж байхад анхаарах.

мэдээлж байх.
6. Хог хаягдлыг ангилан хаях талаар мэдээллийг ажилтнуудад эзэмшүүлэх, сургалт сурталчилгаа явуулах, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж ажиллах.
7. Оршин суугаа газар орчмын хог хаягдлыг цэвэрлэх, олон нийтийг хамарсан ажилд оролцох
8. Хуульд заасан журмын дагуу олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх, хог хаягдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхийг эрх бүхий байгууллага албан тушаалтнаас шаардах.
9. Үүсэн аюултай хог хаягдал, түүний эх үүсвэрийн талаар төрийн болон нутгийн захиргааны байгууллагад мэдээллэх.
10. Дундговь аймгийн Өлзийт сумын төрийн сан банк **100080800947** тоот дансанд төлбөрийн даалгаврын дагуу төлбөрөө төлөх.

**Зургаа. Гэрээний хариуцлага**

